



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 17420

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.30тн багтаамжтай гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех (Уянга, сум) үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: З.Балданням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Г.Гантөмөр (Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны албаны Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (З.Балданням)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0850

D:My Doc. Zahiramj. Zasag darga